



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

“Моннис даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Моннис даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг хувь нийлүүлэгч “Моннис интернэшнл” ХХК-ийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Моннис интернэшнл” ХХК	1,000,000,000.0	500,000,000.0	1,500,000,000.0	100.0
	Нийт	1,000,000,000.0	500,000,000.0	1,500,000,000.0	100.0

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Моннис даатгал” ХХК /С.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

001620